**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Жаргалант сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2024/142/НА-СТА-ТШЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баянхонгор хот<br>2024.02.23 | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br>Ахлах аудитор М.Алтантуяа<br>Утас: 99061829 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Б.Азбаяр<br>Утас: 99061429 Цахим хаяг: Azbayarb@audit.gov.mn<br>Цахим хуудас: www.audit.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ........ 4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ........ 6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ........ 14
4. АУДИТЫН ТАЙЛАН ........ 18
4.1 Ерөнхий зүйл ........ 18
4.2 Материаллаг байдал ........ 18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ........ 18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ........ 19
5.1 Төлбөрийн акт ........ **Error! Bookmark not defined.**
5.2 Албан шаардлага ........ **Error! Bookmark not defined.**
5.3 Зөвлөмж ........ 20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ........ 21

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2024.02.23 № 2/16

танай______________-ны № ______________ -т

ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Б.ӨНӨРБАЯР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө,өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Хүнсний материалын дансанд зарцуулалтын баримтгүйгээр 1,420.0 мянган төгрөгийн хүнсний материалыг зарцуулсан нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, мөн толилуулга гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй зөрчил илэрсэн нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түшингээс хэтрээгүй.

5020098

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 42 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95.7 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **129,418,936.75** | **145,465,256.65** |
| **33** | **АВЛАГА** | 5,320,564.50 | 15,999.40 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 00.00 | 15,999.40 |
| **335** | **Бусад авлага** | 5,320,564.50 | 00.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 5,320,564.50 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 109,098,372.25 | 145,449,257.25 |
| **354** | **Хангамжийн материал** | 77,709,892.25 | 99,263,002.25 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,406,089.00 | 1,836,089.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 14,960,883.25 | 40,089,613.25 |
| 35450 | Барилгын засварын материал | 390,800.00 | 390,800.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 60,952,120.00 | 56,946,500.00 |
| 35600 | Мал амьтад | 31,388,480.00 | 46,186,255.00 |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | 15,000,000.00 | 00.00 |
| 36100 | Барааны нөөц | 15,000,000.00 | 00.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,313,365,009.87** | **1,353,898,538.75** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,313,365,009.87 | 1,353,898,538.75 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,210,553,009.87 | 1,251,086,538.75 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 808,498,605.15 | 899,994,016.15 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -164,501,183.23 | -196,223,668.94 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 226,610,800.00 | 199,800,800.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -147,780,800.04 | -137,613,466.72 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 260,937,665.13 | 292,911,465.13 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -157,667,812.76 | -186,041,860.17 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 118,817,850.00 | 103,891,200.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -46,293,575.72 | -41,764,436.06 |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 194,620,000.00 | 214,620,000.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | -94,357,250.26 | -106,888,250.26 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 451,746,130.00 | 495,557,930.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -240,077,418.40 | -287,157,190.38 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 102,812,000.00 | 102,812,000.00 |
| 39301 | Програм хангамж | 200,000.00 | 200,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -200,000.00 | -200,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 102,812,000.00 | 102,812,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,442,783,946.62** | **1,499,363,795.40** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **63,225.49** | **100,991.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 63,225.49 | 100,991.00 |
| **413** | **Өглөг** | 63,225.49 | 100,991.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 63,225.49 | 100,991.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,442,720,721.13** | **1,499,262,804.40** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,442,720,721.13 | 1,499,262,804.40 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 545,016,013.96 | 545,016,013.96 |
| 51101 | Өмч: - төрийн | 545,016,013.96 | 545,016,013.96 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 805,432,424.69 | 864,418,390.46 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 805,432,424.69 | 807,876,307.19 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 56,542,083.27 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 92,272,282.48 | 89,828,399.98 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,442,783,946.62** | **1,499,363,795.40** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **826,676,940.75** | **1,000,424,186.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **267,445,249.25** | **265,195,635.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 267,445,249.25 | 265,195,635.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 220,178,616.00 | 192,082,635.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,211,525.00 | 6,398,060.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **559,231,691.50** | **735,228,551.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 23,619,091.50 | 1,495,251.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 23,619,091.50 | 1,495,251.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 535,612,600.00 | 733,733,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 535,612,600.00 | 733,733,300.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **691,843,936.07** | **926,525,802.26** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **691,843,936.07** | **926,525,802.26** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 642,907,460.07 | 894,471,549.76 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 224,112,826.00 | 356,399,732.63 |
| 210101 | Үндсэн цалин | 180,999,985.00 | 270,744,439.63 |
| 210102 | Нэмэгдэл | 31,570,836.00 | 74,429,228.00 |
| 210104 | Урамшуулал | 8,901,532.00 | 11,226,065.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 2,640,473.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 29,034,369.49 | 44,525,316.82 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,618,226.36 | 30,310,285.51 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,227,482.47 | 3,608,350.94 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,629,315.15 | 2,877,655.98 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 585,511.32 | 704,005.30 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,973,834.19 | 7,025,019.09 |

| | | | |
|---|---|---|---|
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 54,792,492.00 | 81,393,512.12 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,850,492.00 | 9,681,656.12 |
| 210302 | Түлш, халаалт | 49,942,000.00 | 71,711,856.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 86,249,630.00 | 58,001,565.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,148,190.00 | 8,627,070.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 43,002,655.00 | 45,400,495.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,845,600.00 | 3,589,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 661,000.00 | 385,000.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 33,592,185.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 17,666,400.00 | 20,106,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 629,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 17,037,400.00 | 20,106,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 6,356,000.00 | 14,686,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,356,000.00 | 14,686,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 42,942,194.00 | 70,616,851.54 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 39,420,194.00 | 68,969,351.54 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 400,000.00 | 337,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 218,000.00 | 200,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 240,000.00 | 110,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 564,000.00 | 00.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,300,000.00 | 1,000,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 300,000.00 | 00.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 181,753,548.58 | 248,742,071.65 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 55,090,184.00 | 81,360,870.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 126,663,364.58 | 167,381,201.65 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 48,936,476.00 | 32,054,252.50 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 21,633,000.00 | 16,653,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 11,653,000.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 9,980,000.00 | 16,653,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 27,303,476.00 | 15,401,252.50 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 27,303,476.00 | 14,162,827.00 |
| 213404 | Хөрөнгийн | 00.00 | 1,238,425.50 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **134,833,004.68** | **73,898,383.74** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 17,356,300.47 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 2,356,300.47 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 00.00 | 15,000,000.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | -17,356,300.47 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **134,833,004.68** | **56,542,083.27** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **564,443,216.50** | **746,947,175.50** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **5,211,525.00** | **11,718,624.50** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 5,211,525.00 | 11,718,624.50 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 5,211,525.00 | 11,718,624.50 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,211,525.00 | 11,718,624.50 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **559,231,691.50** | **735,228,551.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 23,619,091.50 | 1,495,251.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 23,619,091.50 | 1,495,251.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 535,612,600.00 | 733,733,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 535,612,600.00 | 733,733,300.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **529,318,517.50** | **714,562,944.50** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **529,318,517.50** | **714,562,944.50** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **474,651,477.00** | **682,508,692.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 224,142,677.00 | 356,326,797.84 |
| 210101 | Үндсэн цалин | 182,914,412.00 | 249,252,062.58 |
| 210102 | Нэмэгдэл | 37,981,567.00 | 81,293,928.26 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 25,780,807.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 3,246,698.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 28,203,313.00 | 44,576,485.50 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,236,794.91 | 30,598,490.32 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,003,600.00 | 3,599,103.21 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,013,179.79 | 2,856,708.82 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 450,033.20 | 660,065.13 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,499,705.10 | 6,862,118.02 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 54,986,400.00 | 81,393,512.12 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,044,400.00 | 9,681,656.12 |
| 210302 | Түлш, халаалт | 49,942,000.00 | 71,711,856.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 26,024,780.00 | 36,718,945.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,084,340.00 | 6,567,070.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,494,840.00 | 25,534,325.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,845,600.00 | 3,589,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 00.00 | 429,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 600,000.00 | 599,150.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 18,003,100.00 | 6,478,730.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,003,100.00 | 378,730.00 |
| 210604 | Урсгал засвар | 17,000,000.00 | 6,100,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 6,356,000.00 | 14,686,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,356,000.00 | 14,686,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 57,547,011.00 | 84,395,611.54 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 54,025,011.00 | 81,600,111.54 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | 500,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 400,000.00 | 359,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 218,000.00 | 218,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 240,000.00 | 218,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 564,000.00 | 00.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,300,000.00 | 1,500,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 300,000.00 | 00.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 59,388,196.00 | 57,932,610.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 59,388,196.00 | 57,932,610.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **54,667,040.50** | **32,054,252.50** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 22,043,000.00 | 16,653,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 11,653,000.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 10,390,000.00 | 16,653,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 32,624,040.50 | 15,401,252.50 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 27,303,476.00 | 14,162,827.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **35,124,699.00** | **32,384,231.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **35,124,699.00** | **32,384,231.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **35,124,699.00** | **32,384,231.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 35,124,699.00 | 32,384,231.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 35,124,699.00 | 32,384,231.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-35,124,699.00** | **-32,384,231.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 443,704,013.96 | 161,423,884.40 | 312,949,614.28 | 00.00 | 918,077,512.64 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **443,704,013.96** | **161,423,884.40** | **312,949,614.28** | **00.00** | 918,077,512.64 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 253,934,740.59 | 00.00 | 253,934,740.59 |
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **545,016,013.96** | **92,272,282.48** | **805,432,424.69** | **00.00** | 1,442,720,721.13 |
| D01 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **545,016,013.96** | **92,272,282.48** | **805,432,424.69** | **00.00** | 1,442,720,721.13 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 2,443,882.50 | 00.00 | 2,443,882.50 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **545,016,013.96** | **92,272,282.48** | **807,876,307.19** | **00.00** | 1,445,164,603.63 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -2,443,882.50 | 00.00 | 00.00 | -2,443,882.50 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 56,542,083.27 | 00.00 | 56,542,083.27 |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **545,016,013.96** | **89,828,399.98** | **864,418,390.46** | **00.00** | 1,499,262,804.40 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | | Хэтрэлт, хэмнэлт | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** | | |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 734,733,300.00 | 720,860,473.00 | 13,872,827.00 | 98.11 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 734,733,300.00 | 720,860,473.00 | 13,872,827.00 | 98.11 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 718,080,100.00 | 704,207,473.00 | 13,872,627.00 | 98.07 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 361,308,400.00 | 356,326,797.84 | 4,981,602.16 | 98.62 |
| 210101 | Үндсэн цалин | 262,652,200.00 | 249,252,062.58 | 13,400,137.42 | 94.90 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210102 | Нэмэгдэл | 98,656,200.00 | 81,293,928.26 | 17,362,271.74 | 82.40 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 25,780,807.00 | -25,780,807.00 | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 46,138,600.00 | 44,576,485.50 | 1,562,114.50 | 96.61 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 31,374,200.00 | 30,598,490.32 | 775,709.68 | 97.53 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,691,100.00 | 3,599,103.21 | 91,996.79 | 97.51 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,952,900.00 | 2,856,708.82 | 96,191.18 | 96.74 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 738,200.00 | 660,065.13 | 78,134.87 | 89.42 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,382,200.00 | 6,862,118.02 | 520,081.98 | 92.95 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 81,673,800.00 | 81,393,512.12 | 280,287.88 | 99.66 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,960,400.00 | 9,681,656.12 | 278,743.88 | 97.20 |
| 210302 | Түлш, халаалт | 71,713,400.00 | 71,711,856.00 | 1,544.00 | 100.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 37,985,200.00 | 36,718,945.00 | 1,266,255.00 | 96.67 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,859,800.00 | 6,567,070.00 | 292,730.00 | 95.73 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 26,399,800.00 | 25,534,325.00 | 865,475.00 | 96.72 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,625,600.00 | 3,589,000.00 | 36,600.00 | 98.99 |
| 210404 | Ном, хэвлэл | 500,000.00 | 429,400.00 | 70,600.00 | 85.88 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 600,000.00 | 599,150.00 | 850.00 | 99.86 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 29,900,000.00 | 28,458,530.00 | 1,441,470.00 | 95.18 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 23,800,000.00 | 22,358,530.00 | 1,441,470.00 | 93.94 |
| 210604 | Урсгал засвар | 6,100,000.00 | 6,100,000.00 | 0.00 | 100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 15,395,700.00 | 14,686,000.00 | 709,700.00 | 95.39 |
| 210702 | Дотоод албан томилолт | 15,395,700.00 | 14,686,000.00 | 709,700.00 | 95.39 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 87,471,400.00 | 84,114,592.54 | 3,356,807.46 | 96.16 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 84,613,400.00 | 81,319,092.54 | 3,294,307.46 | 96.11 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | 500,000.00 | 0.00 | 100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 400,000.00 | 359,500.00 | 40,500.00 | 89.88 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 218,000.00 | 218,000.00 | 0.00 | 100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 240,000.00 | 218,000.00 | 22,000.00 | 90.83 |
| 210807 | Газрын төлбөр | 1,500,000.00 | 1,500,000.00 | 0.00 | 100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 58207000.00 | 57932610.00 | 274,390.00 | 99.53 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 58,207,000.00 | 57,932,610.00 | 274,390.00 | 99.53 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 16653200.00 | 16653000.00 | 200.00 | 100.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 16,653,200.00 | 16,653,000.00 | 200.00 | 100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 16,653,200.00 | 16,653,000.00 | 200.00 | 100.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 734,733,300.00 | 720,860,473.00 | 13,872,827.00 | 100.04 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 733,733,300.00 | 719,860,473.00 | 13,872,827.00 | 100.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 733,733,300.00 | 719,860,473.00 | 13,872,827.00 | 100.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 1,000,000.00 | 1,000,000.00 | 0.00 | 129.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.00 | 1,000,000.00 | 0.00 | 129.00 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 20.00 | 20.00 | 0.00 | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 07.00 | 07.00 | 0.00 | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 07.00 | 07.00 | 0.00 | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 06.00 | 06.00 | 0.00 | 100.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **11,923,875.50** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 10,685,450.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 10,685,450.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,685,450.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,238,425.50 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,238,425.50 |
| 213405 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | 1,238,425.50 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 11,923,875.50 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 11,923,875.50 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,495,251.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 10,428,624.50 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **0.00** |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Жаргалант сумын ЗДТГ нь “Төр засгийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийг оновчтой зохион байгуулж, мэргэшсэн төрийн албан хаагчдаар төрийн албыг бүрдүүлэн иргэдэд төрийн үйлчилгээг ил, тод шуурхай, тэгш хүртээмжтэй хүргэж, сумын хөгжилд дэмжлэг үзүүлэх” эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жаргалант сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Баянхонгор аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсээс гаргасан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Жаргалант сумын ЗДТГ 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 56,579.8 мянган төгрөг буюу 3.9 хувиар *өссөн* байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 129,418.9 | 145,465.3 | 16,046.3 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 5,320.6 | 16.0 | (5,304.6) |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 124,098.4 | 145,449.3 | 21,350.9 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,313,365.0 | 1,353,898.5 | 40,533.5 |
| Үндсэн хөрөнгө | 2,164,243.1 | 2,309,787.4 | 145,544.4 |
| Хуримтлагдсан элэгдэл | (850,878.0) | (955,888.9) | (105,010.8) |
| **Нийт хөрөнгө** | 1,442,783.9 | 1,499,363.8 | 56,579.8 |
| Өр төлбөр | 63.2 | 101.0 | 37.8 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,442,720.7 | 1,499,262.8 | 56,542.1 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 1,442,783.9 | 1,499,363.8 | 56,579.8 |

Авлагын дансны үлдэгдэл 16.0 мянган төгрөг болж 5,304.6 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлгийг авлагаар тусгасан нь буцаж санхүүжсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 145,449.3 мянган төгрөг болж 21,350.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Төсвийн худалдан авалтаар 111,758.8 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар сайн үүлдрийн хуц, бухан бяруу 7,797.8 мянга, Онцгой байдлын газраас урьдчилан сэргийлэх эмчилгээний багц 2,000.0 мянга, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 71,111.0 мянга, нийт 80,908.8 мянган төгрөгийн материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан бөгөөд нийт 167,319.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,309,787.4 мянган төгрөг болж 145,544.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн худалдан авалтаар 35,174.2 мянга, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 80,020.0 мянган төгрөгийн хөрөнгө эзэмшүүлсэнтэй холбоотой байна.Мөн Улсын төсвийн хөрөнгөөр 2,790.0 мянган төгрөгийн мотоцикл хүлээн авч бүртгэсэн байна.

Тайлант онд аймгийн ИТХ-ын 2023 оны 14/30 тоот тогтоолоор 28,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий Ланд 100 автомашин Төрийн хэмнэлтийн хуулийн дагуу шилжүүлсэн ба 2023 оны 13/08 тоот тогтоолоор 36,726.7 мянган төгрөгийн үнэ бүхий 25 нэр төрлийн хөрөнгийг актлах шийдвэр гарсны дагуу үндсэн хөрөнгөөс хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,499,363.8 мянган төгрөг болж 56,579.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээр хуримтлагдсан 56,579.8 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 549,939.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 549,939.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 65,730.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 615,669.7 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 734,733.4 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 720,860.5 мянган төгрөгийг зарцуулж, 14,162.8 мянган төгрөгийн төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 720,860.5 мянган төгрөг буюу 98.1 хувьтай байгаа нь цалингийн зардал 4,981.6 мянга, ажил олгогчоос төлөх НДШ 1,562.1 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 280.3 мянга, хангамж, бараа материалын зардал 1,266.3 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 3,356.8 мянган төгрөгөөр зарцуулаагүй нь голлох нөлөөг үзүүлж байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал | 491,767.6 | 483,882.6 | 7.9 | 98.4 |
| 2 | 80106 Баг, хорооны ҮАЗардал | 86,265.4 | 83,607.9 | 2.7 | 96.9 |
| 4 | 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, | 14,880.0 | 14,880.0 | 0.0 | 100.0 |
| 5 | 81102 Орон нутгийн нөөц хөрөнгө | 58,207.0 | 57,932.6 | 0.3 | 99.5 |
| 6 | 81701 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх | 77,013.4 | 77,013.3 | 0.0 | 100.0 |
| 7 | 82212 Хур хог хаягдал, орчны бохирдол | 6,600.0 | 3,544.1 | 3.1 | 53.7 |
| | НИЙТ | 734,733.4 | 720,860.5 | 13.9 | |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар худгийн усны орлого 3,258.1 мянга, халуун усны түрээсийн орлого 350.0 мянга, отроор ирсэн малчдаас 1,500.0 мянга, Статистикийн хэлтсээс 1,015.6 мянга, өмнөх оны үлдэгдлээс 5,320.6 мянга, Хамтдаа шийдье аян зохион байгуулахад 479.7 мянган төгрөг нийт 11,923.9 мянган төгрөгийг

бүрдүүлж 10,685.5 мянган төгрөгийг зарцуулан 1,238.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тээвэр шатахууны зардалд 22,399.8 мянган төгрөг батлагдсан ба сумд 1 шатахуун түгээх станцтай тул шууд гэрээ байгуулсан байна.

Тус байгууллага нь түлш халаалтын зардалд нийт 71,711.9 мянга, гэрэл цахилгааны зардалд 9,681.7 мянга, батлагдсанаас Баянхонгор Эко дулаан ХХК-тай дулаанаар хангах гэрээ, “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК, цахилгаанаар хангах гэрээг тус тус байгуулж ажилласан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Жаргалант сумын ЗДТГ нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Жаргалант сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 11 дүгээр сарын 23-нд ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсөв 734,733.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 7,347.3 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5,143.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2023 оны гэрэл цахилгааны зардлыг 278.7 мянга буюу 2.8 хувиар хэмнэсэн байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийн хугацаанд нь мэдээлсэн ба аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

*Шийдвэрлэсэн нь*: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж байхыг зөвлөв.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар түлш шатахууны тайлан 715.3 мянган төгрөгийн орлого зарлага, хүнсний материалын данс 1,420.0 мянган төгрөгийн орлого зарлага, бусад хангамжийн материалын дансанд 2,864.0 мянган төгрөгийн орлого 8,571.1 мянган төгрөгөөр эд хариуцагчийн тайланг зөрүүтэй гаргасныг залруулж жилийн эцсийн аудитаар шалгуулахыг зөвлөсөн. Мөн 7,857.6 мянган төгрөгийн баримтын бүрдэл дутуу байсныг дахин шалгуулахыг зөвлөсөн.

### 4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Должмаа гүйцэтгэж аудитаар 110.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 61,694.2 зөвлөмж 4 зөвлөмж өгснийг бүрэн биелүүлсэн талаар тус байгууллагаас 2023 оны 06 дүгээр сарын 03-ны дөр FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 1 | 110.0 | 1 | 110.0 | 100% |
| Албан шаардлага | - | - | - | - | - |
| Зөвлөмж | 4 | 61,694.2 | 4 | 61,694.2 | 100% |
| **Нийт дүн** | **5** | **61,804.2** | **5** | **61,804.2** | **100%** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 13,872.8 мянган төгрөгийн алдаа илэрснийг санхүүгийн тайланд залруулав. Үүнд:

Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн эх үүсвэрээс 13,872.8 мянган төгрөгийг санхүүжилт бууруулж цэвэрлээгүй байсныг Төсвийн гүйцэтгэлийн тайланд залруулав.

Аудитаар нийт 1,420.0 мянган төгрөгийн 1зөрчил[1] илэрснээс 1,420.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоов.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 1,420.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 5,927.3 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

5.1.1 Хүнсний материалын дансанд зарцуулалтын баримтгүйгээр 1,420.0 мянган төгрөгийн хүнсний материалыг зарлагдсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн хуулийн 12.1.4-т заасан "хуулиар зөвшөөрөөгүй бусад хангамжийн материал авахыг хориглоно" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д заасан "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь*: Баримтгүй зарцуулсан 1,420.0 мянган төгрөгийн хүнсний материалын үнийг гарын үсэг зурж буй сумын ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч нараар төсөвт буцаан төлүүлэхээр төлбөрийн актыг тогтоов.

Дээрх актын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

# 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл** /мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн эх үүсвэрээс 13,872.8 мянган төгрөгийг санхүүжилт бууруулж цэвэрлээгүй байсныг Төсвийн гүйцэтгэлийн тайланд залруулав. | 1 | 13,872.8 | | | 1 | 13,872.8 | 1 | 13,872.8 | | |
| Дүн | 1 | 13,872.8 | | | 1 | 13,872.8 | 1 | 13,872.8 | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Хүнсний материалын дансанд зарцуулалтын баримтгүйгээр 1,420.0 мянган төгрөгийн хүнсний материалыг зарлагдсан | 1 | 1,420.0 | 1 | 1,420.0 | | | | |
| **Нийт дүн** | 1 | 1,420.0 | 1 | 1,420.0 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуультай холбоотой зөрчил | | | | | | | | |
| Материаллаг байдалтай зөрчил илрээгүй | 0 | 0 | | | 0 | 0 | | |
| Дүн | **0** | **0** | | | **0** | **0** | | |

------------oOo-------------